

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ 11 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Хуралдаан 2016 оны наймдугаар сарын 30-ны 11 цаг 08 минутад эхэлж, 12 цаг 42 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 1 цаг 34 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1.	Дэрэн сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны даргын албан тушаалд сонгон шалгаруулсан Самдангийн Цогтбаатарт дүгнэлт гаргах тухай	Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд Самдан овогтой Цогтбаатарыг ажиллуулах саналыг дэмжсэн дүгнэлтийг тогтоолоор баталж, Дэрэн сумын ЗДТГ-ын даргад албан тоотоор хүргүүлэхээр шийдвэрлэв
2	Нийгмийн даатгалын хэлтсийн Дэлгэрхангай сум хариуцсан байцаагчийн албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Дэлгэрхангай сум хариуцсан нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2016 оны 03 сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн Рэнчиндавга овогтой Мөнхцэцэгийг томилуулахаар нэрийг дэвшүүлэхээр шийдвэрлэв
3	Цагаандэлгэр, Адаацаг сумдын Соёлын төвийн эрхлэгч, Цагаандэлгэр, Гурвансайхан, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Говь-Угтаал сумын сум дундын эмнэлгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт зарлах тухай	Цагаандэлгэр, Адаацаг сумдын Соёлын төвийн эрхлэгч, Цагаандэлгэр, Гурвансайхан, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Говь-Угтаал сумын сум дундын эмнэлгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зарлаж, 2016 оны 9 сарын 21-нд бүртгэж, 9 сарын 22-23 –ны өдөр шалгалтыг зохион байгуулахаар шийдвэрлэв. Сонгон шалгаруулалтын зарыг ТАЗ хүргүүлж, бусад хэвлэл мэдээллийн хэрэслээр сурталчлахаар болов
4	Нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн сул орон тооны захиалгад мэргэшлийн шалгалт зарлуулах тухай.	Нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн дэс түшмэлийн 5, туслах түшмэлийн 6 хийт 11 ажлын байранд мэргэшлийн шалгалт зарлуулахаар Төв комисст хүргүүлэхээр шийдвэрлэв.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА